



**МОНГОЛБАНК
СУДАЛГАА, СТАТИСТИКИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСАД АЯЛЖ БУЙ ГАДААДЫН ЖУУЛЧДЫН
ЗАРДЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА**

Хураангуй

Төлбөрийн тэнцлийн статистикийн аялал жуулчлалын дансны орлогын гүйцэтгэлийг тооцохын тулд гадаадын жуулчдын Монгол Улсад аялахдаа зарцуулж буй дундаж зардлыг тодорхойлох зорилгоор энэхүү түүвэр судалгааг гүйцэтгэв.

Түүвэр судалгаанд Монгол Улсад аялсан **1,350** жуулчныг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулснаас гадна Монгол Улсад аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч **42** аж ахуйн нэгжээс асуулгын аргаар тоон мэдээллийг авч, нэгтгэн тооцсон бөгөөд судалгааны гол үр дүнгээс дурдвал, гадаадын жуулчид манай улсад дунджаар **9** хонох хугацаандаа **1,463** ам.долларыг зарцуулдаг байна.

I. ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Төлбөрийн тэнцлийн статистикийн хамрах хүрээ, мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд 2017 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Аялал жуулчлалын хөгжлийн төв (АЖХТ)-тэй хамтран “Монгол улсын аялал жуулчлалын орлого, зардлын судалгаа”-г асуулгын аргаар зохион байгууллаа. Судалгааг гадаадын жуулчид болон гадаадын жуулчдад үйлчилгээ үзүүлдэг тур оператор компаниудаас авсан мэдээлэлд үндэслэн тооцож, үр дүнг танилцуулж байна. Судалгааны асуулгыг тараах, цуглуулах ажилд АЖХТ, БОАЖЯам, ХХЕГ, УБТЗ ХНН, МИАТ ХК болон МАЖХолбоо, түүний гишүүн байгууллагуудтай хамтран ажиллаа.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ


2.1. Судалгааны зорилго

Төлбөрийн тэнцэл дэх жуулчлах зорилготой аяллын үйлчилгээний орлогыг Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ)-аас ирүүлдэг жуулчдын тоон мэдээлэлд тохируулга хийн Монголбанкнаас 2011, 2015 оны судалгаагаар тооцсон дундаж зардлын дүнгээр үржүүлэн тооцож байна.

Гадаад, дотоодын инфляцийн түвшин ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан дундаж зардал тогтмол өөрчлөгддөг тул энэ төрлийн түүвэр судалгааг 2-3 жилийн давтамжтай гүйцэтгэж, тооцооллыг шинэчлэх шаардлагатай байдаг. Энэ удаагийн судалгаагаар хувийн болон багцын аяллын дундаж зардлыг шинэчлэн тооцохын зэрэгцээ бусад зардлын дүн, түүний зарцуулалтын мэдээллийг олж авахыг зорилоо. Мөн түүвэр авах байршлыг өргөтгөсөн (Буянт-Ухаа, Алтанбулаг, Замын-Үүд хилийн боомтууд), тур оператор компаниудаас нэмэлтээр судалгаа авсан, салбарын яамны зүгээс аялал жуулчлалын салбарын бодлогын шийдвэрт дэмжлэг болгох зорилгоор гадаадын жуулчдын манай улсад аялах шалтгаан, сэтгэл ханамж, тур оператор компаниудад тулгамдаж буй асуудлын талаар санал зөвлөмжийг агуулсан асуултуудыг тусгасан нь энэ удаагийн судалгааны онцлог байлаа.

2.2. Ерөнхий мэдээлэл

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл дэх аяллын үйлчилгээ, (сая ам.доллар)



Төлбөрийн тэнцлийн статистикаас харахад, Монгол улсын аялал жуулчлалын үйлчилгээний орлого буюу гадаадын иргэдээс хүлээн авсан орлогын хэмжээ нь манай иргэдийн гадаадад аялахдаа зарцуулсан зардлаас бага, цэвэр дүнгээр 2016 онд 166 сая ам.долларын алдагдалтай буюу ДНБ-ий 1.5%-тай тэнцэх хэмжээний гадаад валютыг аялал жуулчлалын шугамаар гадаадад зарцуулсан байна.

Хүснэгт 1. Гадаадын зорчигчдын урсгал¹

Улс	2011	2015	2016
АНУ, Канад	12,344	13,443	15,927
Австрали, Шинэ Зеланд	4,889	4,005	5,040
БНСУ	34,512	36,546	48,567
БНХАУ	104,898	79,961	71,816
ХБНГУ	6,554	7,267	8,534
ИБУИНВУ	5,062	5,072	5,258
ОХУ	80,868	57,716	65,962
Франц	6,781	6,892	8,408
Япон	11,907	15,109	17,571
Бусад европ	12,374	9,459	12,659
Бусад	25,548	34,829	36,299
Нийт	305,737	270,299	296,041

Монгол Улсын хилээр нэвтэрсэн жуулчдын статистикаас үзвэл 2015-2016 оны хооронд гадаадын зорчигчдын тоо 10%-иар өссөн (2011 онтой харьцуулбал 3%-иар буурсан) байна.

Улсаар нь авч үзвэл БНСУ, АНУ, Канад, Франц, ХБНГУ болон Япон улсын зорчигчдын тоо тогтмол нэмэгдсээр байгааг харж болно.

2.3. Түүврийн оновчтой хэмжээ²

Түүврийн эх олонлогийг 2016 онд Монгол Улсын хилээр нэвтэрсэн 296,041 зорчигчид гэж үзсэн бөгөөд үүнээс эх олонлогийг төлөөлөхүйц хамгийн оновчтой түүврийн хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай, +/- 3,5%-ийн алдааны хязгаартай байхаар сонгон тооцоолоход 784 гарч байна.

$$n_0 = \frac{(t)^2 * (p) * (q)}{d^2}$$

Энд, t = Студентийн t тархалтын критик утга; p = түүврийн тодорхой асуултад хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь. Судалгаа хийхээс өмнө энэ үзүүлэлт мэдэгдэхгүй бол 0.5 гэсэн тогтмол хэмжээг ашигладаг; q = түүврийн тодорхой асуултад хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь; d = алдааны хязгаар буюу түүврийн үр дүнд гарсан дундаж утга нь түүврийн хэмжээг Δ хувиар ихэсгэж, бууруулсан ч үр дүн нь ижил гарна гэсэн таамаглал.

Хүснэгт 2. Оновчтой түүврийн хэмжээний тооцоолол

№	Байриул	2016 онд хилээр нэвтэрсэн гадаад жуулчдын тоо. (N)	Түүврийн хэмжээ. (n)								Авсан түүвэр
			Итгэх завсар=95%				Итгэх завсар=99%				
			Ахиуц алдааны утга/Алдааны хязгаар								
			0.05	0.035	0.025	0.01	0.05	0.035	0.025	0.01	
1	Алтанбулаг	47,012	79	161	316	1,977	137	279	546	3,415	256
2	Замын-Үүд	42,501	71	146	286	1,787	124	252	494	3,088	78
3	Буянт-Ухаа	138,844	234	477	934	5,839	403	823	1,614	10,087	1,016
	Нийт	296,041	384	784	1,537	9,604	664	1,354	2,654	16,589	1,350

Эх сурвалж: ХХЕГ

2.4. Түүврийн хэмжээ, шинж чанар


Түүвэр судалгааны хүрээнд 2017 оны III улиралд Буянт-Ухаа (1016), Алтанбулаг (256), Замын-Үүд (78) хилийн боомтуудаас нийт 1350 жуулчнаас анкетын аргаар мэдээлэл цуглуулсан. Мөн 2017 оны II улиралд 42 тур оператор³ компаниас (21,446 жуулчинд үйлчилгээ үзүүлсэн) авсан мэдээллийг харьцуулж үр дүнг тооцоолсон. Түүврийн хэмжээ нь өмнө тодорхойлсон хамгийн бага оновчтой түвшин болох 784-с их байна.

¹ ХХЕГ-ын мэдээ (хувийн болон жуулчлах зорилготой зорчигчдын тоо)

² Оновчтой түүврийн хэмжээг тодорхойлох Кокраны арга

³ АЖХолбооны мэдээлснээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг 120 тур оператор байдаг, үүнээс 35% нь түүвэрт хамрагдсан байна.

Дүрслэл 2. Эх олонлог болон түүврийн бүтцийн харьцуулалт




2016 онд Монгол Улсын хилээр нэвтэрсэн гадаадын жуулчдыг улс орон, бүс нутгаар нь авч үзэхэд БНСУ-ын жуулчид 26%, ОХУ 15%, БНХАУ 14%, Япон 8%, АНУ болон Канадын жуулчид 6%-ийг тус тус эзэлж байна. Түүвэрт хамрагдсан жуулчдын хувьд харгалзан 35%, 4%, 8%, 9%, 8%-ийг эзэлж байгаагаас үзэхэд түүврийн бүтэц нь эх олонлогийн бүтцээ төлөөлж чадахуйц, нийцтэй тархсаныг харуулж байна.

Ш. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ҮР ДҮН


3.1. Аяллын дундаж зардал

Гадаадын жуулчдын Монгол Улсад аялах хугацаандаа буюу эдийн засгийн харьяатад зарцуулж буй дундаж зардал нь тухайн жуулчин аяллаа хэрхэн зохион байгуулсан болон аль улсын тур оператор компаниар үйлчлүүлснээс хамаарч ялгаатай байдаг нь өмнөх судалгааны ажлуудаар тогтоогдсон.

Дүрслэл 3. Аяллаа зохион байгуулсан хэлбэр



Дүрслэл 4. Тур оператор компанийн харьяалал



Судалгаанд хамрагдсан жуулчдын 56% нь тур оператор (үүнээс 53% нь эдийн засгийн харьяат бус, 47% нь эдийн засгийн харьяат)-уудаар үйлчлүүлсэн байна. Жуулчдын дундаж зардлын хэмжээг тооцоход нийт 1350 түүврээс статистикийн тооцооллын чанар хангаагүйг

хасч, үлдсэн 1211 түүврийг ашиглав. Жуулчид Монгол Улсад дунджаар 9 хоног аялдаг бөгөөд багц аялагчид 1,788 ам.доллар, хувийн аялагчид 1,068 ам.долларыг тус тус зарцуулдаг байна. Аяллын зардал ийнхүү 1.7 дахин ялгаатай байгаа нь жуулчлалын байгууллагын үйлчилгээний шимтгэлтэй холбоотой.

Хүснэгт 3. Монгол Улсад зарцуулж буй аяллын дундаж зардал⁴

Улс, бүс	Дундаж хоног	Аяллын дундаж зардал		Дундаж зардал	Зардлын харьцаа (Багц/Хувийн)
		I. Багц аялал	II. Хувийн аялал		
АНУ, Канад	13	3183	1465	2187	2.2
Австрали, Шинэ Зеланд	11	2578	1504	2191	1.7
БНСУ	6	1136	685	1027	1.7
БНХАУ	16	1697	874	1162	1.9
ХБНГУ	12	1473	812	1102	1.8
ИБУИНВУ	10	1609	1114	1304	1.4
ОХУ	11	2013	1029	1147	2.0
Франц	12	3430	1145	2257	3.0
Япон	7	2244	1354	1818	1.7
Өмнөд Ази	8	1272	837	1111	1.5
Бусад европ	12	2437	1380	1957	1.8
Бусад	19	1494	870	1086	1.7
Нийт	9	1788	1068	1463	1.7

Хүснэгт 4. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулсан байдал*⁵

Улс	2017	2015	ТТ*	2017/2015*	2017/ТТ*
АНУ, Канад	2187	2570	2415	-15%	-9%
Австрали, Шинэ Зеланд	2191	2044	1908	7%	15%
БНСУ	1027	1557	1451	-34%	-29%
БНХАУ	1162	1532	1558	-24%	-25%
ХБНГУ	1102	1876	1966	-41%	-44%
ИБУИНВУ	1304	1835	1779	-29%	-27%
ОХУ	1147	1134	1153	1%	-1%
Франц	2257	1274	1350	77%	67%
Япон	1818	1363	1416	33%	28%
Зүүн Ази	1111	1313	1364	-15%	-19%
Бусад европ	1957	1575	1573	24%	24%
Бусад	1086	1940	1364	-44%	-20%
Нийт	1463	1774		-18%	

Монголбанк, АЖҮТөв-тэй хамтран 2015 онд хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулбал, гадаадын жуулчдын Монгол Улсад аялахдаа зарцуулсан дундаж зардлын хэмжээ 18%-иар буурсан, энэ нь Монголд аялах дундаж хугацаа буурсан буюу 14 хоног өнгөрүүлдэг байсан бол 9 хоног болж буурсантай холбоотойгоор тухайн аяллын зарцуулалт буурсан байна.


Мөн өмнө нь хийгдсэн судалгааны түүвэр авсан байршил нь хязгаарлагдмал (Буянт-Ухаа) тул өртөг өндөр жуулчид ихээр хамрагдсан байх магадлалтай, мөн сүүлийн жилүүдийн төгрөгийн эсрэг ам.долларын чангаралтай холбоотой аяллын зарцуулалтын дүн буурахад тодорхой нөлөө үзүүлсэн байж болзошгүй юм.

Одоогийн төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд ашиглаж буй дүнгээс харилцан адилгүй ялгаатай гарч байгаа нь энэ төрлийн тоон мэдээллийг тогтмол шинэчлэх шаардлагатайг харуулж байна.


⁴ Үүнд олон улсын нислэг, тээвэр орохгүй.

⁵ 2011 болон 2015 оны судалгааны үр дүн болон инфляциар засварласан төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд ашиглаж буй үр дүн

Дүрслэл 5. Хувиараа аялагчдын зардлын бүтэц




Дүрслэл 6. Багц аялагчдын зардлын бүтэц




Хувиараа аялагчдын зарцуулсан зардлын бүтцийг авч үзвэл нийт зардлын дунджаар 27%-ийг орон байр, зочид буудлын үйлчилгээнд, 25%-ийг барааний худалдаанд, 23%-ийг хоолны газрын үйлчилгээнд зарцуулдаг байна. Харин багц аялагчдын хувьд нийт зардлынхаа 74%-ийг жуулчлалын компанид төлдөг бөгөөд тухайн төлбөрт байр, орон сууц (18%⁶), хоолны газрын (13%), орон нутгийн тээврийн (33%), үзвэр үйлчилгээний зэрэг бусад үйлчилгээний (23%) зарим төлбөрүүд багтдаг байна.

Дүрслэл 7. Багц аялагчдын төлбөр төлөх хэлбэр



Дүрслэл 8. Төлбөр тооцооны хэлбэр



Багцын аяллын төлбөр төлөхдөө 18% нь Монгол Улс руу шилжүүлдэг, 32% нь Монгол Улсад ирээд төлдөг бол 34% нь гадаад улсын тур компанид төлбөрөө төлдөг байна. Төлбөр тооцооны хэлбэрийг авч үзвэл 26% нь олон улсын карт ашигладаг, 39% нь бэлнээр төлбөрөө хийдэг бол үлдсэн 35% нь хосолмол байдлаар ашигладаг байна. Энэ нь 2015 онд хийгдсэн судалгаатай харьцуулахад жуулчид бэлэн мөнгө ашиглахаас илүү карт, цахим төлбөр тооцоог илүүд үзэх хандлагатай болсон байна.


⁶ Нийт дундаж зардалд эзлэх хувь

3.2. Жуулчдын сэтгэл ханамж

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь Монголын уламжлалт зан заншил, байгаль ан амьтан үзэх зорилгоор ирсэн бөгөөд тур операторуудын үйлчилгээг 38% нь маш сайн, 33% нь сайн, 19% нь дунд гэж үнэлсэн. Мөн байршуулах үйлчилгээний сэтгэл ханамжийн түвшингээ нийт аялагчдын 40% нь сайн, 26% нь дунд, 24% нь маш сайн гэж үнэлсэн. Харин тээврийн үйлчилгээнд өгөх сэтгэл ханамжийн түвшин харьцангуй сул байгаа нь харагдаж байна.

Дахин ирж аялах талаараа 89% нь тийм, 11% мэдэхгүй гэдгээ тур оператор компаниудад илэрхийлсэн байна.

Дүрслэл 9. МУ-ыг сонгон аялах болсон гол шалтгаан



Хүснэгт 5. Жуулчдын өгсөн үнэлгээ

Үнэлгээ	Тур оператор, хөтчийн үйлчилгээ	Байршуулах үйлчилгээ	Хоол, хүнс, зочлох үйлчилгээ	Тээврийн үйлчилгээ
Маш сайн	38%	24%	21%	19%
Сайн	33%	40%	34%	25%
Дунд	19%	26%	30%	26%
Муу	8%	9%	13%	19%
Маш муу	2%	1%	2%	10%

Монгол Улсын аялал, жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэхэд дараах тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэсэн саналыг жуулчид болон тур операторууд өгсөн. Үүнд:

- i. *Олон улсын нислэг, тээврийн хүрэлцээгүй байдлыг сайжруулах.* Гадаад, дотоодын нислэгийн хуваарь төлөвлөгөөт хугацаанаас өөрчлөгддөг, хүрэлцээ муу, хангалтгүй байдаг тул аяллын эрчимтэй үед нэмэлт нислэг гаргах, нислэгийн хуваарийг эрт гаргадаг болох гэх мэт зохицуулалтын арга хэмжээг авах;
- ii. *Тур оператораас бусад аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг үйлчилгээний газруудын стандартыг сайжруулах.* Жуулчны бааз, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ хангалтгүй байдаг;
- iii. *Салбарын нэгдсэн бодлого сул.* Гадаадын улс орнуудад сурталчлах, үйл ажиллагаа зохион байгуулах зэрэгт салбарын нэгдсэн бодлого хангалтгүй;
- iv. *Нийтийн тээврийг сайжруулах.* Улаанбаатар хотын автобус, орон нутгийн галт тэрэг, нислэгийн хуваарь болон чиглэлүүдийн талаар жуулчдад зориулсан мэдээллийн төвийг бий болгох;
- v. *Угаалгын өрөө, хогийн сав.* Хотод болон жуулчны баазуудын ариун цэврийн өрөөг сайжруулах, шинээр бий болгох, хогийн сав хангалттай байрлуулах, шүршүүрийн халуун усыг шийдвэрлэх;
- vi. *Бусад бүтээн байгуулалтын санал.* Сүм, хийдүүдийг засварлах, бусад төрлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар Монгол Улсад аялсан гадаадын жуулчдын дундаж зардлыг шинэчлэн тооцоолсон нь цаашид төлбөрийн тэнцэл, аялал жуулчлалын статистикийн чанарыг сайжруулах ач холбогдолтой боллоо.

Монголд ирсэн жуулчдын хувьд ирсэн улс орноосоо хамаарч зардлууд нь харилцан адилгүй дунджаар 9 хоногт 1,463 ам.доллар зарцуулдаг ба энэ нь Монголбанкнаас 2015 онд хийсэн судалгааны үр дүнгээс 18%-иар буурсан үзүүлэлт юм.

Мөн жуулчдын 56% нь жуулчны компаниар үйлчлүүлсэн, 44% нь хувиараа аяллаа зохион байгуулсан бөгөөд эдийн засгийн харьяатад төлж буй зардлынхаа 39%-ийг бэлнээр, 26%-ийг картаар, үлдсэн 35%-ийг хосолмол байдлаар төлбөр тооцоогоо гүйцэтгэдэг байна. Нийт зарцуулалтын 25 орчим хувийг орон нутгийн тээврийн үйлчилгээнд, 22%-ийг орон байр, зочид буудлын үйлчилгээнд, 18%-ийг бараа худалдаанд зарцуулдаг байна.

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд аяллын дансны орлогыг энэхүү үр дүнгээр шинэчлэн тооцох, эдийн засгийн өөрчлөлт, гадаад харилцаа өргөжин тэлж байгаатай холбогдуулан энэхүү түүвэр судалгааг 2 жилд нэг удаа зохион байгуулж, дундаж зардлын дүнг шинэчилж байх саналтай байна.